



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2018 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 66,339,000.00 (жаран зургаан сая гурван зуун гучин есөн мянган) төгрөгийн балансын үнэ, 16,652,878.00 (арван зургаан сая зургаан зуун тавин хоёр мянга найман зуун далан найман) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг "Засгийн газрын автобааз" улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоо, "Засгийн газрын автобааз" улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал С.Энхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТЭСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮВ  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОП

Э.ЭРДЭНЭХИШИГ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 01 дүгээр сарын 21 ны өдрийн  
 № дугаар тогтоолын хавсралт



Төрийн албаны зөвлөлөөс “Засгийн газрын автобааз” улсын төсөвт үйлдвэрийн газарт  
 балансаас балансад шилжүүлэх автомашин

Д/д	Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Ланд круйзер 200, Суудлын автомашин, 06-91 УБҮ улсын дугаартай, JTMHU03JXC5055842 арлын дугаартай	2011/2012	276,382	66,339,000.00	16,652,878.00	49,686,122.00
<b>Нийт дүн</b>				<b>66,339,000.00</b>	<b>16,652,878.00</b>	<b>49,686,122.00</b>
<b>Нийт дүн</b>				(жаран зургаан сая гурван зуун гучин есөн мянган)	(арван зургаан сая зургаан зуун тавин хоёр мянга найман зуун далан найман)	(дөчин есөн сая зургаан зуун наян зургаан мянга нэг зуун хорин хоёр)